

## НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

### Санал, зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас жил бүр гаргадаг Шударга байдлын үнэлгээгээр яамдын дундаж үнэлгээ 2015 онд 72.3, 2016 онд 69.1, 2018 онд 69.0 байсан бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам 2015 онд 77.2 оноо, 2016 онд 64.0 оноо, 2018 онд 67.1 оноо авснаас үзэхэд сүүлийн 2 жилд тус яам дунджаас доогуур үнэлэгдсэн байна.

Азийн сангаас хийсэн “Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авлигын асуудал” судалгаагаар сургууль, цэцэрлэгт хүүхэд элсүүлэх, анги өөрчлөх, сурлагын дүн, үнэлгээ өөрчлөхөд мөнгө, албан тушаал, танил тал ашиглах явдал нийтлэг байгаа нь тогтоогдсон. Судалгаанд оролцогчдын 40 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд багш, ажилтанд хувьд нь бэлэг сэлт эсвэл мөнгө, 50 гаруй хувь нь хандив тусламж, төлбөр хураамж өгчээ. Тухайлбал, талархал илэрхийлэхэд дунджаар 40-50 мянга, хүүхэд цэцэрлэгт оруулахад 400 мянга, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийг тэтгэлэгт хамруулахад 300 мянга, их дээд сургууль, эсвэл анги өөрчлөхөд 500-800 мянган төгрөг төлсөн бол нэг удаагийн хандив тусламж дунджаар 45 мянга орчим, төлбөр хураамжийн дундаж нь 50 гаруй мянган төгрөг байна. Судалгаанд хамрагдсан нийт эцэг эхчүүдийн 19.5 хувь нь ямар нэг бэлэг сэлт, мөнгө, хандив, тусламж, төлбөр хураамж төлөөгүй байна. Өөрөөр хэлбэл цэцэрлэг, сургуулийн хүүхэдтэй 5 хүн тутмын 4 нь ямар нэг хэлбэрээр төлбөр, мөнгө өгсөн байна. Чанарын судалгааны мэдээллээс үзэхэд авлигад зарцуулсан гэх мөнгөний хэмжээ хэдэн сая төгрөгөөр хэмжигдэж байна. Судалгаанд оролцогч иргэдийн 46 хувь нь салбарын худалдан авах ажиллагаанд авлига их бий гэсэн төсөөлөлтэй байна. Олонх тохиолдолд салбарын дунд, дээд шатны албан тушаалтнууд холбогдож байх бөгөөд тендертэй холбоотой авлигын дүн тухайн гэрээний үнийн дүнгийн 5-10 хувьтай тэнцүү байдаг байна. Тухайлбал, чанарын ярилцлагад оролцсон 13 аж ахуйн нэгжийн зургаа нь авлигын замаар худалдан авах ажиллагаанд нөлөөлж байсан гэжээ.

Энэ байдал цаашид үргэлжлэхийг иргэд буруу гэж үзэж байгаа боловч тоон судалгаанд оролцсон эцэг эхчүүдийн 70 орчим хувь нь бэлэг сэлт, мөнгө өгдөг байдал цаашид хэвээр байна эсвэл нэмэгдэнэ гэсэн гутранги төсөөлөлтэй байгаа нь боловсролын салбарын авлигын эрсдэл ямар хэмжээнд байгааг харуулж байна.

2018 онд Авлигатай тэмцэх газарт боловсролын салбартай холбоотой гэмт хэргийн шинжтэй бус, авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй 111 гомдол ирсэний 19 нь их, дээд сургуультай холбоотой, 42 нь ерөнхий боловсролын сургуультай холбоотой, 38 нь цэцэрлэгтэй холбоотой, 12 нь төрийн байгууллагын удирдлагатай холбоотой гомдол байсан бөгөөд нийт гомдлын 72% нь ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгтэй холбоотой, түүн дотроо элсэлтийн шалгалт, бүртгэлтэй холбоотой гомдол дийлэнх нь байсан байна.

Цэцэрлэгийн бүртгэлийг цахимаар зохион байгуулж эхэлсэн нь дэвшилттэй талтай ч, бүртгэл явагдсанаас хойш шалгахад цахим бүртгэлээр шалгараагүй хүүхдүүд элсэж орсон хэвээр байна. Тухайлбал, 2018 оны 11 дүгээр сард Авлигатай тэмцэх газраас Нийслэлийн гурван цэцэрлэгт очиж нөхцөл байдлыг шалгахад нэг цэцэрлэгт цахим бүртгэлээр шалгараагүй, ямар аргаар орсон нь тодорхойгүй 26 хүүхэд, нөгөө цэцэрлэгт нь 15 хүүхэд хүмүүжсэн байсан.

Энэ оны хувьд ч мөн адил ерөнхий боловсролын сургуулийн бүртгэлтэй холбоотой гомдол, мэдээлэл, хүсэлт тус газарт ирэх нь ихэсч байгаа тул 2019-2020 оны хичээлийн жилд Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойргийг шинэчлэн болон шинээр тогтоох, сургууль, цэцэрлэгт шинээр хүүхэд элсүүлэн суралцуулах үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, ил тод байдлаар зохион байгуулж ажиллана уу.

Боловсролын салбарын хөгжилд төрийн болон иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тулгарч буй асуудал, бэрхшээлийг тэдний дэмжлэгтэйгээр шийдвэрлэж, даван туулах нь тухайн салбар дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг багасгах томоохон хүчин зүйл болохыг анхаарч ажиллахыг хүсье.